



ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 02 сарын 23 өдөр

Дугаар А/65

Чойр

Шивээговь сумын Засаг даргын
захирамжийг хүчингүй болгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.3, 77 дугаар зүйлийн 77.1, Захиргааны ерөнхий хуулийн 47 дугаар зүйлийн 4.1.1, 47.1.6, 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Шивээговь сумын Засаг даргын 2014 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн “Газар ашиглуулах тухай” А/62 дугаар захирамжаар “Гарьд зам” ХХК-д олгосон газар ашиглах эрхийг хүчингүй болгохдоо газар эзэмших эрхийг хүчингүй болгох гэж утга агуулгын илэрхий алдаатай, газар ашиглах гэрээ байгуулаагүй атлаа Газрын тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1.6 дахь заалтыг үндэслэсэн нь 2021 оны “Газар эзэмших эрхийг хүчингүй болгох тухай” А/215 дугаар захирамжийг гаргасан нь илт хууль бус захиргааны акт гэж үзэх үндэслэлтэй байх тул хууль тогтоомжид нийцээгүй Шивээговь сумын Засаг даргын 2021 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн “Газар эзэмших эрхийг хүчингүй болгох тухай” А/215 дугаар захирамж, илт хууль бус захиргааны акт болох 2021 оны А/215 дугаар захирамжийг үндэслэж гарсан Шивээговь сумын Засаг даргын 2021 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн “Ажлын хэсэг байгуулах тухай” А/217 дугаар захирамжийг тус тус хүчингүй болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Г.БАТЗАМ